

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬААТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН 2018 ОНЫ  
04 ДҮГЭЭР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН  
/2018.03.26-2018.04.25/**

2018 оны 04 дүгээр  
сарын 25-ны өдөр

Даланзадгад сум

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

**Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:**

**1.1. Виз олголтын талаар:**

Тайлант хугацаанд Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-ын дагуу хилийн боомтод виз олгоход шаардлагатай бичиг баримтыг биедээ авч явсан нийт БНХАУ-ын 3 иргэнд зохих ангиллын визийг олгож төлбөрийг төрийн санд төвлөрүүлэн ажилласан.

Үүнд:

- Олон удаагийн /Multiple re-entry/-1
- Визийн шилжүүлэг-3

Нийт 4 гадаадын иргэнд виз олгож, визийн хуудасны үнэ болох 28.779 /хорин найман мянга долоон зуун далан ес/ төгрөгийг Гадаадын иргэн, харьяатын газрын Голомт банкны 1320000114 тоот дансанд, тэмдэгтийн хураамжийн 600.000 /зургаан зуун мянга/ төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын 100110000941 тоот дансанд тус тус тушаалган ажилласан болно.

Тайлант хугацаанд Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор зорчсон БНХАУ-ын 4111 иргэний баримт бичиг болон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

*Орох чиглэлд:2047*

*Гарах чиглэлд:2064*

**1.2. Түр ирэгчийн бүртгэл, хасалт, оршин суух зөвшөөрлийн хасалт:**

Тайлант хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн болон торгуулийн арга хэмжээ авагдсан нийт 63 гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл, 6 иргэний хасалт хийж ажилласан байна.

ХОНЗҮ-ээр зорчигч гадаад иргэдийн хяналтын талаар:

Тайлант хугацаанд хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 68 иргэнийг бүртгэж, 68 иргэнд хасалт хийж тухайн иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.

Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар: Тайлант хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн “Тавантолгой шин” ХХК-ийн БНХАУ-ын 50 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч төвд хүргүүлсэн.

### **1.3. Хилийн чанад болон Гадаадын иргэн, харьяатын газарт алдаатай олгогдсон, зөвшөөрөлгүй олгогдсон визийг засварласан болон хүчингүй болгосон талаар:**

Тайлант хугацаанд БНХАУ-ын Бээжин хот дахь ЭСЯ, Эрээн хот, Хөх хотын Консулын газраас БНХАУ-ын 18 иргэнд олгосон В, J ангиллын нэг болон олон удаагийн визийн хүчинтэй хугацааг алдаатай олгосон байсныг засварлаж, 28 дугаар бүхий визийн тэмдгээр баталгаажуулан, хил нэвтрүүлсэн.

### **1.4. Гадаадын иргэдийн хяналт шалгалтын хүрээнд:**

Тайлант хугацаанд төлөвлөгөөт 1, төлөвлөгөөт бус 1 нийт 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, шалгалтад 6 аж ахуйн нэгж, байгууллагын 3 улсын нийт 245 гадаадын иргэн хамрагдсан байна.

Үүнд, Өмнөд бүс дэх газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн ӨМ-2018/03 тоот удирдамжийн хүрээнд Өмнөговь аймгийн Ноён, Гурвантэс сумдын нутаг дэвсгэрт үйл уул уурхай, ашигт малтмал, хайгуул, нүүрс тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын иргэдийн баримт бичигт шалгалт хийхэд ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Тус газрын даргын энэ оны 03 дугаар сарын 30-ны өдрийн ӨМ-2018/04 тоот удирдамжийн хүрээнд Дундговь аймгийн Мандалговь, Дэлгэрцогт сумдын нутаг дэвсгэрт дэд бүтэц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих төслийн үйл ажиллагаа явуулж байгаа “ТЕВА” ХХК-ийн 25 гадаадын иргэний бичиг баримтад шалгалт хийхэд БНХАУ-ын 5 иргэн нь “J” ангиллын визээр хил нэвтэрсэн боловч тус компанид тогооч болон барилгын ажил хийж байсан нь шалгалтаар очих үеийн нөхцөл байдал, өөрсдийн гаргасан тайлбар, Монгол Улсын визээр нотлогдсон.

### **1.5. Албадан гаргасан талаар:**

Хяналт шалгалтын хүрээнд Монгол Улсад ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 5 иргэнийг ГИЭЗБТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1.7, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа тогтоох журам”-ын 3.7 дугаар зүйлийг тус тус үндэслэн байгууллагын даргын 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/116 дугаар тушаалаар Монгол Улсад гурван жилийн хугацаанд дахин орж ирэх эрхийг хасч албадан гаргасан болно.

### **1.6. Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэдийн талаар:**

Гашуунсухайт, Шивээхүрэн авто замын боомтоор ГИЭЗБТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн, ярилцлага хийж БНХАУ-ын 13 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцааж ажилласан.

**1.7 Торгуулийн арга хэмжээ авагдсан талаар:** Хяналт шалгалтыг явуулж Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 16.2.1.1 дэх заалтыг үндэслэн БНАСАУ-ын 4 иргэнд нийт 400.000 /дөрвөн зуун мянга/ төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

## **Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд**

### **2.1. Захиргааны чиглэлээр хийсэн ажил**

Монгол Улсын ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 оны 04 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд Өмнөговь аймаг, Гашуунсухайт боомтод ажилласантай холбогдуулан газрын дарга, виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, сүлжээний инженер, мэргэжилтэн нар Гашуунсухайт боомтод бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Өмнөговь аймгийн Прокурорын газраас орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хууль хяналтын болон төрийн байгууллагуудын дунд энэ оны 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн хэлэлцүүлэг, сургалтад газрын дарга, хяналтын улсын ахлах байцаагч, виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн нар хамрагдлаа.

Өмнөговь аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Төрийн албаны манлайллыг хангах нь” сэдэвт сургалт 2018 оны 03 дугаар 29-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд уг сургалтад ахлах нягтлан бодогч, Захиргааны ахлах мэргэжилтэн нар хамрагдсан болно.

Өмнөговь аймгийн Насан туршийн боловсрол ТББ-тай хамтран албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор газрын төвийн албан хаагчдад 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс англи хэлний сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Удирдлагын академиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт зайн сургалтад мэргэжилтэн Д.Эрдэнэбулган хамрагдсан бөгөөд сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүй, мэргэжлийн ёс зүйн чиглэлээр лекц, видео хичээлийг цахим хэлбэрээр хүлээн авч судлан амжилттай суралцсан.

## **2.2. Өргөдөл, гомдлын мэдээ**

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/- 3
  - Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо- 3
  - Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо /Ерөнхий газарт/-0
  - Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
  - Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-1/
  - Ерөнхий газраас ирсэн бичиг-7
  - Ерөнхий газарт явуулсан бичиг /албан тоот-0, илтгэх хуудас-9/
  - Бусад байгууллагад хүргүүлсэн бичиг /албан тоот-7/
  - Бусад байгууллагаас ирсэн бичиг-5
  - Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-1

## **2.3. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:**

Тус Газрын 03 дугаар сарын шилэн дансны мэдээллийг шивж, мэдээг Санхүүгийн хэлтэс, Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

Батлагдсан төсөв болох 30.551.100 төгрөгийн санхүүжилт орсон бөгөөд энэ оны 04 дүгээр сард 18 албан хаагчид 12.665.332 төгрөгийн цалин олгож, татварт 1.838.002 төгрөг, нийгмийн даатгалд 3.798.533 төгрөгийн, хангамж бараа материалын зардалд 2.601.161 төгрөг, байр ашиглахтай холбоотой зардалд 1.456.366 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн төрийн сангаар баталгаажуулан, өр авлаггүй ажилласан.

Газрын 2018 оны нэгдүгээр улиралын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

**2.4. Мэдээлэл технологийн чиглэлээр:**

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган, бүсийн хэмжээнд гарсан эвдрэл, гэмтлийг тухай бүр нь засч сайжруулан ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын цахим хуудсанд тус газрын 2018 оны 04 дугаар сарын төлөвлөгөө, 03 дугаар сарын төлөвлөгөөний биелэлт, тайлан, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр байршуулж олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

**ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР**